

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ  
2 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

**НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа зохион байгуулж, 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр Аймгийн Засаг дарга, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоотой Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг байгуулсан. Тус хэлэлцээрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, цалин хөлс, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хүний хөгжлийг дэмжих зэрэг асуудлуудыг харилцан тохиролцож баталсан.

Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP систем нэврүүлэх ажлын хүрээнд цахим сургалт зохион байгуулж, 20 байгууллагын 60 албан хаагч хамрагдсан.

**ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2021 оны 2 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 880 664 мянган төгрөг төвлөрүүлэхээс 968 176 мянган төгрөг төвлөрүүлж, 109.94 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 140 701 мянган төгрөг төвлөрүүлэхээс 140 701 мянган төгрөгийг төвлөрүүлж 100 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 138 614 мянган төгрөг төвлөрүүлэхээс 138 614 мянган төгрөг төвлөрүүлж 100 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 660 914 мянган төгрөг төвлөрүүлэхээс 780 000 мянган төгрөг төвлөрүүлж 118.02 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 635 болж, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд төсвийн болон орон нутгийн өмчит 81 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 88.3 хувьтай байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр**

№	Төрөл	2020.02.25		2021.02.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/
1	Өндөр настан	1748	1514243.0	1892	1806162.0
2	Хөгжлийн бэрхшээлтэй	352	223370.7	314	213099.6
3	Тэжээгчээ алдсан	133	82341.1	121	82326.3
4	Үйлдвэрийн осол	27	23046.2	42	46111.1
<b>Нийт дүн</b>		<b>2260</b>	<b>1843001.0</b>	<b>2369</b>	<b>2147699.0</b>

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2020.02.25		2021.02.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	197	21859.7	113	15998.7
2	ЖБА тэтгэмж	53	81861.2	67	135978.2
3	Оршуулга	9	9000.0	12	12000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	0	0	6	6410,8
5	Ажилгүйдэл	42	70798.8	29	45073,6

	<b>Нийт дүн</b>	<b>301</b>	<b>183519.7</b>	<b>227</b>	<b>215461,3</b>
--	-----------------	------------	-----------------	------------	-----------------

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.02.25	2021.02.25
Шинээр	58	84
Мөнгө тушаасан	381	347
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	42695,9	27719,4

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1149 заалт, 12148 хүний нэр, 1153 байгууллагын нэр, 3454 газар зүйн нэр, 1646 хуудас баримт программд холбож, 312 хуудас баримтыг цахимжуулах ажлын хүрээнд засварлаж, 1539 хуудас баримт скайнердсан. Архивын баримтаас 10 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан - 18
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 59
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 30
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 6
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 51
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 37

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 2
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Гэрээний бүртгэл - 34
- Барьцааны гэрээний бүртгэл - 209
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 3

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 1

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 133
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар – 172

Нийт 305 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

**Цагдаагийн хэлтэс нь:** 2021 оны 2 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 113 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан.

Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэмийн үеэр байнгын болон явуулын 5 постонд аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 33 төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын алба хаагч нартай хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгэж зөрчил гаргасан 1038 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас 37085000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 59 хүнийг эрүүлжүүлж, 13 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 11 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор сар шинийн баярыг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхгүй байх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тусгайлсан чиг үүрэг

бүхий байгууллага, төрийн болон төрийн өмчит нийт 40 байгууллагын 395 ажилтан, алба хаагч хяналтын 8 пост, явган болон машинт хөдөлгөөнт эргүүлийн 17 чиглэлд хуваарийн дагуу 5 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэн ажилласан.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Хэргийн газрын үзлэгт 27 удаа оролцсоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 3, зам тээврийн ослын 3, хулгайлах гэмт хэрэг 2, дээрэмдэх гэмт хэрэг 1, бусад хэргийн газрын үзлэгт 18 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 418 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь:** 2020 оны 2 дугаар сард төлбөрийн 154 гүйцэтгэх баримт бичгээс 24 гүйцэтгэх баримт бичгийн 247137.8 мянган төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 15.5 хувьтай байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулж, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт, мал эмнэлгийн хяналтын чиглэлээр 16 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав. Шалгалтын явцад 47 зөрчил илрүүлж, зөрчлийн 29 буюу 62 хувийг газар дээр нь арилгуулав. Шалгалтаар илэрсэн зөрчилд үндэслэн 2 газарт зөрчил арилгуулахаар албан шаардлага хүргүүлж, хэрэгжилт 83 хувьтай байна. Халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангаагүй 2 газрын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоон, зөрчлийг арилгуулж, үйл ажиллагааг нь сэргээсэн.

Эрүүл ахуй, халдвар хамгаалал, эм био бэлдмэл, эмчилгээний чанар, стандартын байдалд хяналт тавих зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын бэлэн байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийв. Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар 4 байгууллагад 28 заалт бүхий улсын байцаагч нарын хамтарсан албан шаардлага хүргүүлж, вакцины бэлэн байдлыг хангуулах чиглэлээр гарсан холбогдох тушаал, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Улаанбаатар хотоос хүнсний татан авалт хийж буй тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хяналт хийж, нийт 8 газрын хүнс, барааг нэгдсэн 1 цэгт байршуулж, жолооч, ачигч нарыг худалдаа эрхлэгчид болон иргэдтэй ойрын зайнаас харьцахгүйгээр зохион байгуулж, зөвлөгөө өгч ажиллав. Мөн бусад хүнс тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналтын чангатган ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын удирдамж, улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар, иргэд, ААНБ-аас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу нийт 11 чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг зохион байгуулж, улсын байцаагчийн 10 албан шаардлага, 5 дүгнэлт, 3 зөвлөмж, 4 акт тус тус боловсруулж хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагуудад хүргүүлэв.

Хими, нян судлалын лабораторид хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 3, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 1, мах махан бүтээгдэхүүний 1, нийт 5 сорьцонд 30 үзүүлэлтээр химийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Эерэг сорьц илрээгүй.

**Онцгой байдлын 2 дугаар сарын 25-ны өдөр боловсролын байгууллагын үйл ажиллагаа** эхлэх болсонтой холбогдуулан коронавируст халдвар сургууль, цэцэрлэгийн дунд тархах эрсдэлийн үнэлгээг тус тус хийж гүйцэтгэлээ. Эрсдэлийн үнэлгээгээр халдвар тархах эрсдэл өндөр үнэлэгдсэн тул урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын арга

хэмжээг авах талаар 16 заалт бүхий зөвлөмжийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд банк, банк бус санхүүгийн байгууллага, ломбард, нийт 8 аж ахуйн нэгж байгууллагад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулж, 18 зөрчлийг илрүүлж, 10 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 8 зөрчилд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчын заавал биелүүлэх албан шаардлагыг хүргүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллах талаар мэргэжил, арга зүйн заавар зөвлөмжийг өгсөн.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн 1 удаагийн дуудлага бүртгэгдэж, гал түймэр унтраах аврах 37 дугаар ангийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэсэн.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Боловсролын хүрээлэнгээс “Чадварлаг багш” арга хэмжээг танилцуулах сургалт зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулгын хоцрогдлыг арилгах арга хэмжээг зохион байгуулж, 6 цэцэрлэгийн 45 багшийг хамруулсан.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Өсвөр үе, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өөрсдийн эрх, үүрэг, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Ирээдүйн хөтөч-2021" цахим илтгэлийн уралдааныг 2021 оны 1 дүгээр сарын 8-аас 2 дугаар сарын 7-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 18 оролцогч хамрагдлаа.

Түр хамгаалах байранд 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс 2 дугаар сарын 22-ны өдрүүдэд үл хайхрах хүчирхийлэлд өртөж, хүнс тэжээлийн дутагдалд орсон бага насны 3 хүүхэд, бэлгийн хүчирхийллийн хохирогч 1 хүүхдийг хүлээн авч, хоол хүнс, дулаан хувцас, амин дэм, витаминлаг бүтээгдэхүүнээр хангаж, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилж, шаардлагатай эм бэлдмэлээр хангасан. Тус хүүхдүүдийн гэр бүл, эцэг эх, асран халамжлагч нарт эцэг, эхийн үүрэг хариуцлагын талаар сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан, бага насны 3 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх арга хэмжээг авсан.

**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2020 оны 02 сар	2021 оны 02 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	69	52
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	70	54
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	10	13
Эмнэлгийн нас баралт	0	3
Хоног болоогүй нас баралт	0	1
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	969	347
Амбулаторийн үзлэг	17243	10350
Халдварт өвчин	25	3

2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 19457 хүнийг коронавируст халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулснаас

хийгдсэний 5774 хүнд PCR-ийн шинжилгээ, 13 683 хүнд түргэвчилсэн оношлуурын шинжилгээ хийсэн.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Тайлант сард 4 аж ахуй нэгж, байгууллагаас 10 сул ажлын байрны захиалга ирүүлсний дагуу 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна.

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, их дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 14 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 263 иргэн хамрагдаж 71.8 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 235 иргэнд 21.1 сая төгрөг, амьжиргааг дэмжих тэтгэмжийг 49 иргэнд 14.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийг 47 иргэнд олгож 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” тайлант сард 1 удаа хуралдаж, 4 хүүхдийн асуудлыг хэлэлцэн байнгын асаргааг шинээр тогтоож эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлсэн.

### ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймаг дундын Малх отрын бүс нутагт 7 аймгийн 31 сумын 166 малчин өрхийн 187.5 мян.толгой мал оторлож байна. Мөн отрын бүсээс гадна Улаанбаатар хот, Төв, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн 103 өрхийн 78.8 мян.толгой мал отроор өвөлжиж байна.

Манай аймгаас Дорнод, Дорноговь, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дундговь, Сүхбаатар аймагт нийт-43 өрхийн 30.6 мян.тол мал отроор өвөлжиж байна. Дорноговь аймгийн зарим сумын нутагт отроор өвөлжиж байгаа 13 малчин өрхөд аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөцөөс 130 боодол өвсийг тусламжаар үнэгүй хүргэсэн.

Аймгийн хэмжээнд гурван цэгт өвс, таван цэгт тэжээл худалдаалж байна. Өвсний үнэ 14500-16000, тэжээл төрөл, хэмжээнээсээ хамаараад 25000-70000 төгрөгийн үнэтэй байна.

Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс малчдад хөнгөлттэй үнээр өвс олгож байна.

Дундговь аймгаас отроор Говьсүмбэр, Хэнтий, Төв аймгуудад өвөлжиж байгаа 566 малчин өрхөд тэжээлийн тусламж үзүүлэх ажлыг Баянтал суманд зохион байгуулсан.

2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш өссөн дүнгээр 2871 толгой мал хорогдоод байна. Малын хорогдол 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна.

№	Сумын нэр	Оны эхний мал	Хорогдсон мал						Оны эхний малд эзлэх хорогдлын хувь
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
1	Баянтал	69705	839		26	26	189	598	1.2
2	Сүмбэр	322066	1253		12	11	487	743	0.3
3	Шивээговь	59226	779		6	2	295	476	1.3
	Дүн	450997	2871	0	44	39	971	1817	0.6

Аймгийн хэмжээнд мах 46.5 тн буюу 28 хоног, гурил 104 тн буюу 75 хоног, сүү 4.07 буюу 2 хоног, төрөл бүрийн будаа 29.6 тн буюу 43 хоног, төмс 20.8 тн буюу 12 хоног, хүнсний ногоо 13.6 тн буюу 4, хоног элсэн чихэр 4.6 тн буюу 10 хоног, давс 3.03 тн буюу 11 хоног, савласан ус 17.9 тн буюу 1 хоног, өндөгний 0.24 тн буюу 1 хоног, ургамлын тос 7.2 тн буюу 23 хоногийн нөөцтэй байна.

2021 оны 2 дугаар сарын байдлаар Сум хөгжүүлэх сангаас зээл олгогдоогүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй 157 зээлдэгчийн 1.1 тэрбум төгрөг байна. Тайлант сард 22.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 18 иргэний 7.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 2 дугаар сарын үнийн мэдээ:**

Зах зээлд худалдаалагдаж буй төмс 100 төгрөгөөр, сонгино 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /1-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	9000	8500	+500
		Цул	12000	10000	+1000
2	Хонины мах	Ястай	7500	7000	+500
		Цул	9000	8000	-
3	Адууны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
4	Ямааны мах	Ястай	6000	5500	-
		Цул	6500	6000	-
5	Тахианы мах	Гуя	10500	7900	
		мөч	8000	7900	
6	Лууван	Монгол	2000	1100	+200
		Хятад			
7	Төмс	монгол	+1300	900	+50
		хятад			
8	Байцаа	Монгол	800	600	-
		Хятад			-
9	Чинжүү	Монгол	7500	7000	-
		Хятад	6500	4500	
10	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	4400	2300	+100
		Хятад	-	1400	-
12	Улаан лооль	Монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
14	Элсэн чихэр	Монгол	2800	2300	+400
15	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	+200
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	3450	3000	+150
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
17	Тараг	Задгай	2200	2000	-

		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	1150	-
19	Өндөг	Монгол	550	480	+30
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
21	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** “Хямд Амар” аялал жуулчлалын үзэсгэлэнг 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Уг үзэсгэлэнгийн хүрээнд “Боржигин голомт” жуулчны бааз, “Сүмбэр Алт”, “Оргил зочид” буудлуудад тус тус мэдээллийг танилцуулаад байна.

2021 оны аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2014-2017 оны хооронд хийгдсэн ойн зурвасын хамгаалалтын хашаануудыг сэргээн засварлах ажлын тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр гэрээ байгуулсан.

Сум дундын ойн ангитай хамтран “Хэрлэн гол”-ын дагуу байрлах 45 га талбай байгалийн ойн сангийн 3 га талбайд унаж гэмтсэн мөчрийг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

2020 оны мөчрийн дундаж ургалтын голч 0.4-1 см, урт нь 0.6-2 метр ургалттай байгаа бөгөөд 500 ширхэг мөчир бэлтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулж буй “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/13 дугаар захирамжаар байгуулан, зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг баталж аймгийн хэмжээнд байгаа эвдэрсэн газруудын хэмжээг нарийвчлан тогтоох, 2021 онд нөхөн сэргээлт хийх газрын судалгаа гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

2 дугаар сарын 1-19-ний өдрийн хооронд азотын давхар исэл (NO<sub>2</sub>) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>3</sub>) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 39 удаа, мөн 14 удаагийн дээжинд шинжилгээ хийж, дундаж азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.013 мкг/мг, хүхэрлэг хий (SO<sub>3</sub>) 0.023 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Газрын төлбөр, татварын систем дээр аймгийн хэмжээнд 1132 нэгж талбарт 2323.2 сая газрын төлбөрийн ногдуулалт үүсгэсэн. Аймгийн хэмжээнд 11603 нэгж талбараас 7258 нэгж цахим системд бүртгэгдэж 62.5 хувьтай, 2418 барилга байгууламжаас 656 барилга орж 27.1 хувьтай байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 онд нийт 1 640 405.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 11 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийхээр төлөвлөснөөс 3, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийхээр төлөвлөснөөс 3, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлаад байна. Мөн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажлын тендер шалгаруулалтыг зарласан.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [govisumber.gov.mn](http://govisumber.gov.mn) сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалты үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулсан.

**Орон нутгийн өмчийн талаар:** Орон нутгийн өмчийн харилцааны асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, хуулийн этгээдүүдийн 2021 оны “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулан, 2020 оны жилийн эцсийн өмчийн мэдээ тайланг нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлээд байна.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Малын сэг зэм устгалыг зохион байгуулж, нийт 375 тонн сэг зэмийг устгалд оруулсан.

Сумын хэмжээнд төв суурин газрын хаягийн завсарлалтын ажлыг бүрэн хийж дууссан.

Коронавирус цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд цахимаар мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөмж, зөвлөгөөг байнга хүргэж байна.

**Шивээговь сум:** Сумын шуурхай штабаас Улаанбаатар хот болон өөр аймаг орон нутаг руу зорчих зөвшөөрлийг 117 иргэнд олгоод байна.

Суманд отроор 24 малчин өрхийн 444 бод, 15171 бог, нийт 15615 толгой мал өвөлжиж байна.

Бүх нийтийн цэвэрлэгээг 2 дугаар сарын 8, 19-ний өдрүүдэд зохион байгуулан, нийт 8 га талбайн 5.8 тн хог хаягдлыг төв хогийн цэгт зөөж тээвэрлэсэн.

**Сүмбэр сум:** Сумын шуурхай штабаас хүнс тээвэрлэх, гэртээ харих, эрүүл мэнд, ар гэрийн гачигдлаар гэх мэт шалтгаанаар 81 автомашин, 334 иргэнд Улаанбаатар хотруу, 227 автомашин, 518 иргэнд бусад аймаг, орон нутагруу явах зөвшөөрлийг тус тус олгосон.

Сумын хэмжээнд гэрийн ажиглалтанд 355 иргэн байна.

2021 оны 2 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд аймгийн нөөцөөс тус суманд хуваарилагдсан 3000 боодол өвсийг малчдад олгох ажлыг зохион байгуулан, 2400 боодол өвсийг тус бүр 8000 төгрөгөөр 240 малчин өрхөд олголоо.

Сумын хэмжээний гэр оронгүй иргэдийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд өмнөх онтой харьцуулахад гэр оронгүй иргэдийн тоо 3-аар өссөн байна. Дэлхийн Зөн ОУБ Бор-Өндөр 1 ОНХөтөлбөрт гэр оронгүй 7 өрхийн гэр хүссэн өргөдлийг хүргүүлснээс 5 өрхөд гэр олгохоор шийдвэрлэсэн.

“Маскаа зүү, гараа угаа” аяны хүрээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой 10 өрхийн хүүхдэд короно вирусээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, маск зүүж, гар угаах дадал олгох сургалтыг эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж, гар угаах болон дархлаа дэмжих багцыг олгосон.

Сум хөгжүүлэх сангаас зээл аваад хугацаандаа зээлээ төлж барагдуулаагүй болон чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй 9 иргэнд сумын Засаг даргын “Төлбөр төлж барагдуулах тухай” хугацаатай албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу 1 зээлдэгч 12.5 сая төгрөгийн зээлийг бүрэн төлж барагдуулсан байна.



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**